

2018 он

НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Банк бус санхүүгийн байгууллагуудын 2018
оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн
нэгтгэлийн танилцуулга

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага
тойруу 3, Засгийн газрын IV байр. Утас: 51-261668

Агуулга

1. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	1
1.1 Ерөнхий төлөв байдал	1
1.2 Статистик үзүүлэлтүүд	2
2. АКТИВЫН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	6
2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт	6
2.2 Зээл.....	8
2.2.1 Зээлийн зориулалт	8
2.2.2 Зээлийн багцын чанар	9
2.2.3 Зээлдэгчид	10
2.2.4 Зээлийн жигнэсэн дундаж хүү.....	10
3. ПАССИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ӨӨРЧЛӨЛТ	11
3.1 Өр төлбөр.....	11
3.2 Өөрийн хөрөнгө	14
3.3 Хорооны 2017 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт.....	15
4. ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	16
4.1 Орлого.....	16
4.2 Зарлага	17
4.3 Ашигт ажиллагаа	17
5. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	18
5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	18
5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	18
5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	18
6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД	20
6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд	20
6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд.....	21
6.3 Гадаад валютын арилжааны ББСБ-ууд	22
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ	25
ДҮГНЭЛТ.....	25

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 2018 онд гарсан тогтоол	1
Хүснэгт 2 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл	1
Хүснэгт 3 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо	2
Хүснэгт 6 Харилцагчид	2
Хүснэгт 7 Ерөнхий статистик үзүүлэлтүүд, банктай харьцуулснаар /тэрбум төгрөгөөр/	3
Хүснэгт 8 ББСБ-уудын тархалт /Улаанбаатар хот/	3
Хүснэгт 9 ББСБ-уудын тархалт /Хөдөө орон нутаг, бүсээр/	4
Хүснэгт 10 Активын бүтэц /сая төгрөгөөр/	6
Хүснэгт 11 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/	6
Хүснэгт 13 Авлага /тэрбум төгрөгөөр/	8
Хүснэгт 14 Үндсэн ба биет бус хөрөнгө /тэрбум төгрөгөөр/	8
Хүснэгт 15 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/	9
Хүснэгт 16 Ерөнхий статистик /харилцагчид/	10
Хүснэгт 17 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 18 Дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/	13
Хүснэгт 19 Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/	13
Хүснэгт 22 Бусад пассив /сая төгрөгөөр/	14
Хүснэгт 23 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Улаанбаатар хот/	15
Хүснэгт 24 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сум/	15
Хүснэгт 25 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Бусад аймаг, сумдад/	15
Хүснэгт 26 Санхүүгийн үйлчилгээний орлого /сая төгрөгөөр/	17
Хүснэгт 27 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/	17
Хүснэгт 28 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШҮ	18
Хүснэгт 29 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШҮ	18
Хүснэгт 30 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШҮ	18
Хүснэгт 31 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	19
Хүснэгт 32 Орон нутгийн ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл /давхардсан тоогоор/	20
Хүснэгт 33 Орон нутгийн ББСБ-уудын активын бүтэц	21
Хүснэгт 34 Орон нутгийн ББСБ пассивын бүтэц	21
Хүснэгт 35 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл /давхардсан тоогоор/	21
Хүснэгт 36 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив	22
Хүснэгт 37 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив /мянган төгрөгөөр/	23
Хүснэгт 38 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив /сая төгрөгөөр/	23
Хүснэгт 39 Орлогын бүтэц /мянган төгрөгөөр/	23
Хүснэгт 40 ГВА эрхэлдэг ББСБ-уудын арилжааны дүн мэдээ /2018 он/	24

Зургийн жагсаалт

Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо	1
Зураг 2 Хувь нийлүүлсэн хөрөнгөтэй холбоотой гарсан 373 тушаал /улирлаар/	1
Зураг 3 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо	2
Зураг 4 Санхүүгийн програм ашиглалт /ББСБ-ын тоогоор/	3


Зураг 5 Улаанбаатар хотын ББСБ-ууд болон салбаруудын тархалт.....	4
Зураг 6 Мөнгөн хөрөнгийн бүрдэл /сүүлийн 5 жилээр/	6
Зураг 7 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/	7
Зураг 8 Богино хугацаат хөрөнгө оруулалт /сая төгрөгөөр/	7
Зураг 9 Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	7
Зураг 10 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/	8
Зураг 11 Олгосон болон төлөгдсөн зээл /иргэн, хуулийн этгээд/	8
Зураг 12 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/.....	9
Зураг 13 Зээлийн чанар (нийт зээлд эзлэх хувь).....	9
Зураг 14 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа	9
Зураг 15 Зээлдэгчдийн боловсрол	10
Зураг 16 Зээлийн жигнэсэн дундаж хүү.....	10
Зураг 17 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	11
Зураг 18 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	13
Зураг 19 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/	14
Зураг 20 Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг /сая төгрөгөөр/.....	14
Зураг 21 Өөрийн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	14
Зураг 22 Ашигт ажиллагааны үзүүлэлт.....	16
Зураг 23 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/	16
Зураг 24 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/.....	16
Зураг 25 Үндсэн бус үйл ажиллагааны орлого	17
Зураг 26 Ашигийн өсөлт /хувиар/.....	18
Зураг 27 Зохистой харьцаа	18
Зураг 28 Орон нутгийн ББСБ-ууд, орон нутаг дахь салбаруудын тархалт	20
Зураг 29 Орон нутгийн ББСБ-уудын зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	21
Зураг 30 Хүүгийн бус зардлын бүтэц.....	23
Зураг 31 ГВА эрхэлдэг ББСБ-уудын арилжааны дүн /2016-2018 он/	23

1. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Ерөнхий төлөв байдал

2018 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 539 ББСБ байгаа нь 2017 оноос 5 ББСБ буюу 0.9 хувиар өссөн байна.

Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо



Эдгээр 539 ББСБ-аас гадаадын хөрөнгө оруулалттай 29 ББСБ байгаа бол хөдөө орон нутагт 73 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна.

2018 онд Хорооны хуралдаанаар ББСБ-уудтай холбоотой 82 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэжээ.

Хүснэгт 1 2018 онд гарсан тогтоол

Тогтоолын утга	Тогтоолын тоо
Шинэ тусгай зөвшөөрөл	15
Нэмэлт тусгай зөвшөөрөл	27
Түдгэлзүүлсэн	хэсэгчлэн 1 бүхэлд нь 21
Сэргээсэн	хэсэгчлэн 1 бүхэлд нь 6
Хүчингүй	хэсэгчлэн 1 бүхэлд нь 10
НИЙТ	82

Үүнд 15 хуулийн этгээдэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 27 ББСБ-д 36 төрлийн нэмэлт тусгай зөвшөөрөл олгох, 21 ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь түдгэлзүүлэх, 1 ББСБ-ын үйл ажиллагааг


хэсэгчлэн түдгэлзүүлэх, 6 ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь сэргээх, 1 ББСБ-ын үйл ажиллагааг хэсэгчлэн сэргээх болон 10 ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь хүчингүй болгох, 1 ББСБ-ын үйл ажиллагааг хэсэгчлэн хүчингүй болгох шийдвэрийг тус тус гаргасан байна.

Хүснэгт 2 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл

	2014	2015	2016	2017	2018
Шинээр олгосон ТЗ	120	80	72	31	15
Хүчингүй	5	8	4	15	10
Түдгэлзүүлсэн	5	6	0	23	22
Сэргээсэн	1	5	1	8	7
Нийт ББСБ	378	450	518	534	539

2018 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбартай холбоотой Хорооны даргын 417 тушаал гарчээ. Үүнээс 322 ББСБ /Нийт 373 тушаал гарсан, 274 ББСБ 1 удаа, 46 ББСБ 2 удаа, 1 ББСБ 3 удаа, 1 ББСБ 4 удаа өөрчлөлт оруулсан/ 123.6 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулж, 10 ББСБ оноосон нэрээ өөрчилсөн бол Улаанбаатар хотод 51, хөдөө орон нутагт 18 нийт 69 салбар, 1 ББСБ төлөөлөгчийн газар нээж, 1 ББСБ-ын 2 салбар хаах асуудлыг шийдвэрлэсэн байна.

Зураг 2 Хувь нийлүүлсэн хөрөнгөтэй холбоотой гарсан 373 тушаал /улирлаар/



• Үйл ажиллагааны төрөл

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 539 ББСБ 9 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 787 үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 492 ББСБ буюу 91.3% зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 349 ББСБ

буюу 64.7% нь дагнан эрхэлж байгаа бол 157 ББСБ буюу 29.1% гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 44 ББСБ буюу 8.2% дагнан эрхэлж байна.

Хүснэгт 3 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо


№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2017	2018	тоо	хувь
	Нийт ББСБ	534	539	5	0.9%
1	Зээл	482	492	10	2.1%
	Үүнээс: Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг	360	349	-11	-3.1%
2	Факторингийн үйлчилгээ	21	22	1	4.8%
3	Төлбөрийн баталгаа гаргах	16	18	2	12.5%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	2	3	1	50.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	15	25	10	66.7%
6	Гадаад валютын арилжаа	145	157	12	8.3%
	Үүнээс: Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг	49	44	-5	-10.2%
7	Итгэлцлийн үйлчилгээ	28	30	2	7.1%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	7	9	2	28.6%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	31	31	0	0.0%

1.2 Статистик үзүүлэлтүүд

2018 оны жилийн эцсийн тайлан мэдээг ирүүлбэл зохих 539 ББСБ-аас 97.4% буюу 525 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд дор дурдсан нэр бүхий 14 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

2018 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 4875 хувь нийлүүлэгчдийн 539 ББСБ, 230 салбар нэгж, 5 төлөөлөгчийн газар, 2784 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт давхардсан тоогоор 1,601,749 харилцагчдад хүрч үйлчилж байна.

Зураг 3 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо



• Харилцагчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсч 1,6 саяд хүрлээ. Тэдгээрийн 48.3% нь эмэгтэй, 51.5% нь эрэгтэй, 0.1% нь хуулийн этгээд байгаа ба 79.9 хувийг 2 ББСБ-ын харилцагчид бүрдүүлж байна.

Хүснэгт 4 Харилцагчид

	ББСБ тоо	Хувь	Харилцагчдийн тоо	Хувь
100-аас доош	334	62.0%	12,145	0.8%
100-1000	159	29.5%	42,458	2.7%
1001-10,000	35	6.5%	113,181	7.1%
10,000-1,000,000	10	1.9%	249,867	15.6%
1,000,000-аас дээш	1	0.2%	1,184,098	73.9%
НИЙТ	539	100.0%	1,601,749	100.0%

Хувьцаа эзэмшигчид

2018 оны жилийн эцсийн байдлаар 539 ББСБ-ын 4875 хувьцаа эзэмшигч байна. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийг оролцуулалгүйгээр 1042 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар өссөн үзүүлэлт юм.

Нийт 539 ББСБ-ын 302 нь 1 хувьцаа эзэмшигчтэй, 231 ББСБ нь 2-9, 6 ББСБ нь 10-аас дээш хувьцаа эзэмшигчтэй байна.

• Ажиллагсад

539 ББСБ-д 2784 ажилтан ажиллаж байгаа нь өмнөх оноос 12.6 хувь буюу 311 ажилтнаар нэмэгдсэн дүн юм. Нийт ажилчдын 57.0% буюу 1586 нь эмэгтэй, 43.0% буюу 1198 нь эрэгтэй ажилчид байна.

Хүснэгт 5 Ерөнхий статистик үзүүлэлтүүд, банктай харьцуулснаар /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2017	2018	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	969.2	1284.9	32.6%
Банкны салбартай харьцуулахад хувиар	3.4%	3.9%	0.5%
Нийт өөрийн хөрөнгө	758.2	977.4	28.9%
Банкны салбартай харьцуулахад хувиар	22.8%	30.0%	7.2%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	595.4	740.6	24.4%
Банкны салбартай харьцуулахад хувиар	89.90%	83.8%	-6.1%
Нийт зээл	638.0	869.2	36.2%
Банкны салбартай харьцуулахад хувиар	4.8%	5.1%	0.3%
Нийт орлого	195.9	259.5	32.5%
Нийт зарлага	129.1	158.4	22.7%
Цэвэр ашиг	66.8	101.1	51.4%


2018 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.3 их наяд төгрөг хүрсэн нь банкны салбарын 3.9%-тай тэнцэж байна. Активын өсөлтийн 73.2 хувийг зээлийн үлдэгдэл, пассивын өсөлтийн 46.0 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 32.5 хувиар буюу 63.6 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 22.7 хувиар буюу 29.3 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 51.4 хувиар буюу 34.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

• Програм ашиглалт

2018 оны жилийн эцсийн байдлаар 539 ББСБ-ын 340 нь буюу 63.1% нь үйл ажиллагаандаа санхүүгийн програм ашиглаж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 466 ББСБ-ын 307 нь буюу 65.9%, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 73 ББСБ-ын 33 нь буюу 45.2% нь санхүүгийн програмтай байна.

Зураг 4 Санхүүгийн програм ашиглалт /ББСБ-ын тоогоор/



ББСБ-уудын дийлэнх нь “Ай Би Ай” ХХК-ийн Спинел болон Даймонд програм, “Трейпсити” ХХК-ийн Ачидбанкир болон MARS програмуудыг ашиглаж байна.

• Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 86.5% буюу 466 ББСБ, салбаруудын 70% буюу 161 салбар байршиж байна. Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын 66.3% буюу 309 ББСБ Сүхбаатар болон Чингэлтэй дүүрэгт хамгийн их үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Налайх болон Багануур дүүрэгт хамгийн бага буюу 1 ББСБ, нийт 6 салбар үйл ажиллагаа эрхэлж байна. Багахангай дүүрэгт банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Нийт 4 ББСБ-ын 5 төлөөлөгчийн газар бүртгэлтэй байгаа ба Улаанбаатар хотын Багануур, Баянгол болон Сонгинохайрхан дүүрэг, Булган аймгийн Булган сум болон Америкийн Нэгдсэн улсын Вашингтон хотод тус тус байршиж байна.

Хүснэгт 6 ББСБ-уудын тархалт /Улаанбаатар хот/

Дүүрэг	ББСБ	Салбар	Нийт	Эзлэх хувь
Сүхбаатар	161	21	182	29.0%
Чингэлтэй	148	26	174	27.8%
Баянгол	69	33	102	16.3%
Баянзүрх	51	44	95	15.2%
Хан-Уул	28	14	42	6.7%
Сонгинохайрхан	8	17	25	4.0%

Багануур	1	4	5	0.8%
Налайх	0	2	2	0.3%
Багахангай	0	0	0	0.0%
НИЙТ	466	161	627	100%

Орон нутагт нийт ББСБ-ын 13.5% буюу 73 ББСБ, салбаруудын 30% буюу 69 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.


Хүснэгт 7 ББСБ-уудын тархалт /Хөдөө орон нутаг, бүсээр/

Бүс	ББСБ	Салбар	Нийт	Эзлэх хувь
Хангайн бүс	24	26	48	35.3%
Төвийн бүс	22	17	37	27.2%
Зүүн бүс	13	11	23	16.9%

Баруун бүс	9	5	16	11.8%
Говийн бүс	5	10	12	8.8%
НИЙТ	73	69	136	100.0%

Нийт 67 ББСБ-ын 230 салбар бүртгэлтэй байгаа ба үүнээс 10-аас дээш салбартай 5 ББСБ-ын 85 салбар, 6-9 салбартай 6 ББСБ-ын 49 салбар, 2-5 салбартай 23 ББСБ-ын 61 салбар, 1 салбартай 35 ББСБ-ын 35 салбар Улаанбаатар хотын 8 дүүрэг, Монгол улсын 17 аймагт үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 5 Улаанбаатар хотын ББСБ-ууд болон салбаруудын тархалт



2. АКТИВЫН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт

2018 онд ББСБ-уудын актив 1.3 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 32.6% буюу 315.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 8 Активын бүтэц /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2017 дүн	2018 дүн	Нийт хөрөнгөнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				дүн	хувь
<i>Эргэлтийн хөрөнгө</i>	932,691.6	1,234,705.7	96.1%	302,014.1	32.4%
Мөнгөн хөрөнгө	264,057.8	315,113.9	24.5%	51,056.2	19.3%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	2,742.7	1,837.5	0.1%	-905.2	-33.0%
Зээл (цэврээр)	582,002.0	804,745.6	62.6%	222,743.6	38.3%
Нийт зээл	638,007.8	869,222.4	67.6%	231,214.6	36.2%
(Зээлийн эрсдэлийн сан)	56,005.8	64,476.9	5.0%	8,471.0	15.1%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	125.0	7,292.9	0.6%	7,167.9	58.3 дахин
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	8,110.7	10,223.0	0.8%	2,112.4	26.0%
Бусад хөрөнгө	75,653.5	95,492.8	7.4%	19,839.3	26.2%
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>	36,487.4	50,191.7	3.9%	13,704.3	37.6%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр)	36,487.4	50,191.7	3.9%	13,704.3	37.6%
Нийт хөрөнгийн дүн	969,179.0	1,284,897.4	100.0%	315,718.4	32.6%

Салбарын нийт активын 96.1 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.9 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. Эргэлтийн хөрөнгө 32.4% буюу 302.0 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нийт активын 87.2% буюу 1,119.9 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгө болон цэвэр зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Активын гол өөрчлөлтүүдийг харвал цэвэр зээлийн үлдэгдэл 38.3% буюу 222.7 тэрбум төгрөгөөр, мөнгөн хөрөнгө 19.3% буюу 51.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 41 ББСБ нийт активын 45.9 хувийг, 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 375 ББСБ нийт активын 51.0 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 123 ББСБ нийт активын 3.1 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 9 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/

Интервал	ББСБ тоо	Дүн	Эзлэх хувь
1 тэрбумаас доош	123	39.2	3.1%
1-4.9 тэрбум хүртэл	375	655.3	51.0%
5 тэрбум ба түүнээс дээш	41	590.4	45.9%
НИЙТ	539	1284.9	100.00%

• Мөнгөн хөрөнгө

Нийт активын 24.5% буюу 315.1 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө байна. Үүнээс 150.4 тэрбум төгрөг бэлэн мөнгө хэлбэрээр, 109.5 тэрбум төгрөг нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд, 55.3 тэрбум төгрөг нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжид байршиж байна. 2017 оноос бэлэн мөнгөний үлдэгдэл 7.1 хувиар буурсан бол, хадгаламж 1.3 хувиар, харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө 5.8 хувиар өссөн байна.

Зураг 6 Мөнгөн хөрөнгийн бүрдэл /сүүлийн 5 жилээр/




• Богино хугацаат хөрөнгө оруулалт

2018 оны жилийн эцсийн байдлаар богино хугацаат хөрөнгө оруулалт нь нийт активын 0.1 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оноос 33.0% буюу 905.2 сая төгрөгөөр буурсан байна. 5 ББСБ-ын 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, 10 ББСБ-ын 2.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хасагдсан бөгөөд богино хугацаат хөрөнгө оруулалтын 33.0 хувийн бууралтад 1 ББСБ-ын 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хасагдсан нь голлон нөлөөлсөн байна.

19 ББСБ 1.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүний 91.3% буюу 1.7 тэрбум төгрөгийг 3 ББСБ-ын хөрөнгө оруулалт, 8.1% буюу 149.6 сая төгрөгийг 5 ББСБ-ын хөрөнгө оруулалт, 0.5 хувийг 10 ББСБ-ын тус бүр 1.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

Зураг 7 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/



Богино хугацаат хөрөнгө оруулалтын 96.8 хувийг хувьцаагаарх, 2.9 хувийг Засгийн газрын бондоорх, 0.3 хувийг бусад хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

Зураг 8 Богино хугацаат хөрөнгө оруулалт /сая төгрөгөөр/




Арилжааны үнэт цаасанд нийт богино хугацаат хөрөнгө оруулалтын 95.2% буюу 1.7 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын үнэт цаасанд 4.8% буюу 87.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

- Факторингийн тооцооны авлага, өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө, бусад хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгө

Факторингийн тооцооны авлага өмнөх оноос 58.3 дахин нэмэгдсэн ба тусгай зөвшөөрөлтэй 22 ББСБ-аас 3 ББСБ 7.3 тэрбум төгрөгийн факторингийн тооцооны авлага бүртгэгдсэн байна.

Өмчлөх бусад хөрөнгө өмнөх оноос 0.9 тэрбум төгрөгөөр буурч 1.2 тэрбум төгрөгт, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө 2.4 тэрбум төгрөгөөр өсөж 11.3 тэрбум төгрөгт хүрч тэдгээрт нийт 2.2 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.


Зураг 9 Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө



Бусад хөрөнгө өмнөх оны мөн үеэс 26.2% буюу 19.8 тэрбум төгрөгөөр өсөж 95.5 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт активын 7.4 хувийг бүрдүүлж байна. 2018 оны жилийн эцсээр бусад хөрөнгийн 52.3 хувийг хуримтлуулж тооцсон хүүгийн

авлага, 22.7 хувийг цэвэр авлага, 25.0 хувийг бусад актив бүрдүүлж байна.

Зураг 10 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/



2018 оны жилийн эцсийн байдлаар чанаргүй авлага 727.1 сая төгрөг байгаа ба үүний 93.3%-д буюу 678.3 сая төгрөгийн авлагын эрсдэлийн сан байгуулсан байна.

Хүснэгт 10 Авлага /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2017	2018	Өөрчлөлт		Нийт авлагад эзлэх хувь
			Дүн	Хувь	
Нийт авлага	17.9	22.4	4.50	25.2%	100%
(Авлагын эрсдэлийн сан)	1.0	0.7	(0.3)	-33.1%	3.03%
Хэвийн	16.3	21.0	4.7	29.1%	93.98%
Хугацаа хэтэрсэн	0.5	0.6	0.1	24.7%	2.77%
Чанаргүй:	1.1	0.7	(0.4)	-32.9%	3.25%
Хэвийн бус	0.03	0.01	(0.0)	-81.3%	0.03%
Эргэлзээтэй	0.1	0.1	(0.0)	-7.8%	0.51%
Муу	0.9	0.6	(0.3)	-34.6%	2.71%
Нийт авлага (төгрөгийн)	15.0	18.0	3.0	20.3%	80.43%
Нийт авлага (валютын)	2.9	4.4	1.5	50.4%	19.57%

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 539 ББСБ-ын 61.5 тэрбум төгрөгийн үндсэн ба биет бус хөрөнгөнд 11.3 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Хүснэгт 11 Үндсэн ба биет бус хөрөнгө /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2017	2018	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Үндсэн ба биет бус хөрөнгө	45.5	61.5	16.0	35.2%
Барилга байгууламж	15.4	21.8	6.4	41.3%
Техник хэрэгсэл	16.1	22.8	6.7	41.9%
Тавилга эд хогшил	6.1	7.7	1.6	25.9%
Дуусаагүй барилга	3.6	4.6	0.9	25.7%
Биет бус хөрөнгө	4.2	4.6	0.4	8.6%
Хуримтлагдсан элэгдэл	9.0	11.3	2.3	25.5%
Барилга байгууламжийн	1.0	1.6	0.6	61.3%
Техник хэрэгслийн	5.8	6.9	1.1	18.9%
Тавилга эд хогшлын	2.1	2.7	0.6	26.9%
ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	36.49	50.19	13.7	37.6%


2.2 Зээл

2018 оны жилийн эцсийн байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөөлтэй 492 ББСБ 234,080 зээлдэгчдийн 869.2 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь нийт активын 67.6 хувийг бүрдүүлж байна.

2.2.1 Зээлийн зориулалт

2017 оны жилийн эцэст 482 ББСБ 638.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан ба 450 ББСБ нийт 1.2 их наяд төгрөгийн зээл олгож, 459 ББСБ-ын 947.7 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2018 оны жилийн эцсийн байдлаар 474 ББСБ-ын 869.2 тэрбум төгрөгийн зээлийн эцсийн үлдэгдэлтэй гарчээ.


Зураг 11 Олгосон болон төлөгдсөн зээл /иргэн, хуулийн этгээд/




Олгосон зээлийн 83.8% буюу 989.2 тэрбум төгрөгийг иргэдэд олгосон бол 16.2% буюу 190.5 тэрбум төгрөгийг хуулийн этгээдэд олгосон бол төлөгдсөн зээлийн 84.0% буюу 795.6 тэрбум төгрөг нь иргэдээс, 16.0% буюу 152.0 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс төлөгдсөн байна.

Олгосон болон төлөгдсөн зээлийг авч үзвэл, хэрэглээний зээлд 659.8 тэрбум төгрөгийн зээл олгож, 520.2 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн бол худалдааны салбарт 190.0 тэрбум төгрөгийн зээл олгож, 167.7 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгджээ.

Зураг 12 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/



Зураг 13 Зээлийн чанар (нийт зээлд эзлэх хувь)



2.2.2 Зээлийн багцын чанар


Хүснэгт 12 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/

Зээлийн чанарын ангилал	2017 дүн	2018 дүн	Нийт зээлд эзлэх хувь	Өөрчлөлт дүн	Өөрчлөлт хувь
Хэвийн	527.0	752.9	86.6%	225.9	42.9%
Хугацаа хэтэрсэн	29.9	33.4	3.8%	3.5	11.7%
Чанаргүй:	81.1	82.9	9.5%	1.9	2.3%
Хэвийн бус	17.6	15.7	1.8%	(1.9)	-10.8%
Эргэлзээтэй	14.2	19.0	2.2%	4.8	33.8%
Муу	49.3	48.2	5.5%	(1.1)	-2.1%
(Зээлийн эрсдэлийн сан)	56.0	64.5	55.4%	8.5	15.1%
Нийт зээл	638.0	869.2	100.0%	231.2	36.2%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	694.0	933.7	-	239.7	34.5%
Нийт зээл (төгрөгийн)	605.3	838.6	96.5%	233.3	38.5%
Нийт зээл (валютын)	32.7	30.6	3.5%	(2.1)	-6.4%

Нийт зээлийн үлдэгдлийн 752.9 тэрбум төгрөг буюу 86.6 хувийг хэвийн зээл, 33.4 тэрбум төгрөг буюу 3.8 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 82.9 тэрбум төгрөг буюу 9.5 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 55.4%-д эрсдэлийн сан байгуулсан байна.

Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан өмнөх оны мөн үеэс 0.8, 3.2 пунктээр буурсан бол хэвийн зээл 42.9% буюу 225.9 тэрбум төгрөгөөр өсөж нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.0 пунктээр өссөн байна.

Зураг 14 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа



Нийт зээлийн эцсийн үлдэгдэлд эзлэх валютын зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 пунктээр буурсан, төгрөгийн зээлийн хэмжээ 1.6 пунктээр өссөн дүнтэй гарчээ.

2.2.3 Зээлдэгчид

2018 оны жилийн эцсийн байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 492 ББСБ-ын 234,080 зээлдэгч бүртгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өссөн үзүүлэлт бөгөөд 1 ББСБ-ын зээлдэгчид 4.2 дахин өссөн нь энэ өсөлтийн 52.8 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 13 Ерөнхий статистик /харилцагчид/

Харилцагчдын мэдээлэл	Тоо	Хувь
Нийт харилцагчдын тоо	1,601,749	100.0%
Үүнээс: Эмэгтэй	774,429	48.3%
Хуулийн этгээд	2,337	0.1%
Зээлдэгчдийн тоо	234,080	100.0%
Хэвийн	216,318	92.4%
Хугацаа хэтэрсэн	8,754	3.7%
Чанаргүй:	9,008	3.8%
Хэвийн бус	2,520	1.1%
Эргэлзээтэй	2,865	1.2%
Муу	3,623	1.5%
Зээлдэгчдийн насжилт	232,863	100.0%
18-35 насны	125,454	53.9%
36-45 насны	63,052	27.1%
46-55 насны	32,957	14.2%
55-аас дээш	11,400	4.9%
Зээлдэгчдийн боловсрол	232,863	100.0%
-Дээд	141,290	60.7%
-Тусгай дунд	19,644	8.4%
-Бүрэн дунд	57,209	24.6%
-Дунд	13,890	6.0%
-Бага	830	0.4%

Тэдгээрийн 92.4% буюу 216,318 нь хэвийн, 3.7% буюу 8,754 хугацаа хэтэрсэн, 1.1% буюу 2,520 нь хэвийн бус, 1.2% буюу 2,865 нь эргэлзээтэй, 1.5% буюу 3,623 муу зээлдэгчид байна.

Насжилтын хувьд авч үзвэл нийт зээлдэгчдийн 81.0% буюу 188,506 нь 18-45 насны, 14.2% буюу 32,957 нь 46-55 насны, 4.9% буюу 11,400 нь 55-аас дээш насны иргэд байна.

Зураг 15 Зээлдэгчдийн боловсрол



Боловсролын түвшингөөр дээд болон тусгай дунд боловсролтой иргэд нийт зээлдэгчдийн 160,934 буюу 69.1 хувийг бүрдүүлж байгаа бол бүрэн дунд боловсролтой иргэд 57,209 буюу 24.6 хувийг, бага болон дунд боловсролтой иргэд 14,720 буюу 6.4 хувийг бүрдүүлж байна.


2.2.4 Зээлийн жигнэсэн дундаж хүү

2018 оны жилийн эцсийн байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 492 ББСБ-аас 450 ББСБ нийт 1.2 их наяд төгрөгийн зээл олгосон бөгөөд олгосон зээлийн дээд хүү 10.0%, доод хүү 1.0%, жигнэсэн дундаж хүү 3.3% байна.

ББСБ-уудын олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 3.3%-тай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 пунктээр буусан үзүүлэлт юм. Банкны салбартай харьцуулахад жигнэсэн дундаж хүү 1.9 пунктээр өндөр байна.

/338 ББСБ 1.0 их наяд төгрөгийн олгосон зээлийн хүү ирүүлсэн, 100 ББСБ-ын 163.9 тэрбум төгрөгийн олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2018.III улирлаар ирүүлсэн дүнгээр, 12 ББСБ-ын 9.2 тэрбум төгрөгийн олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2018.III улирлын дунджаар бодсон болно./

Зураг 16 Зээлийн жигнэсэн дундаж хүү



3. ПАССИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ӨӨРЧЛӨЛТ

Салбарын нийт хөрөнгийн 23.9% буюу 307.5 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 76.1% буюу 977.4 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын нийт өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 14 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2017	2018	Нийт хөрөнгөнд эзлэх хувь	Өөрчлөлт	
	дүн	дүн		Дүн	Хувь
<i>Өр төлбөр</i>	211,011.1	307,453.8	23.9%	96,442.7	45.7%
Санхүүгийн эх үүсвэр	39,217.7	57,607.1	4.5%	18,389.4	46.9%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	112,761.7	151,009.6	11.8%	38,247.9	33.9%
Бусад эх үүсвэр	6,711.2	15,668.3	1.2%	8,957.1	133.5%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	6,876.9	23,477.8	1.8%	16,600.9	241.4%
Төслийн зээлийн санхүүжилт	14,869.9	17,848.8	1.4%	2,978.9	20.0%
Бусад өр төлбөр	30,573.7	41,842.2	3.3%	11,268.5	36.9%
<i>Эздийн өмч</i>	758,167.9	977,443.6	76.1%	219,275.7	28.9%
Хувьцаат капитал	595,389.1	740,759.0	57.7%	145,369.9	24.4%
Бусад өмч	6,570.8	10,598.7	0.8%	4,027.9	61.3%
Сангууд	429.6	532.7	0.0%	103.1	24.0%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	155,071.8	224,586.5	17.5%	69,514.7	44.8%
Хоёрдогч өглөг	706.6	966.6	0.1%	260.0	36.8%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	969,179.0	1,284,897.4	100.0%	315,718.4	32.6%

3.1 Өр төлбөр

ББСБ-ын нийт өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 96.4 тэрбум төгрөгөөр буюу 45.7 хувиар өсөж 307.5 тэрбум төгрөг хүрсэн нь пассивын өсөлтийн 30.5 хувийг бүрдүүлж байна.


- **Итгэлцлийн үйлчилгээний өглөг**

Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 30 ББСБ-ын 24 нь 57.6 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлсэн нь салбарын нийт пассивын 4.5 хувьтай тэнцэж байна.

11 ББСБ 1 тэрбум төгрөг хүртэлх дүнгээр 4.6 тэрбум төгрөгийн, 13 ББСБ 1 тэрбум төгрөгөөс дээш дүнгээр 53.0 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн 57.6 тэрбум төгрөгийн 83.2% буюу 47.9 тэрбум төгрөгийг 24 ББСБ төгрөгөөр, 16.8% буюу 9.7 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 10 ББСБ валютаар татан төвлөрүүлсэн байна.

Зураг 17 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



- **Дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг**

2018 оны жилийн эцсийн байдлаар нийт ББСБ-уудын 13.5% буюу 73 ББСБ дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагын 151.0 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байгаа нь нийт хөрөнгийн 11.8 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оноос 38.2 тэрбум төгрөгөөр буюу 33.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

Дотоодын банк санхүүгийн байгууллагуудаас 71 ББСБ 111.0 тэрбум төгрөг, гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас 5 ББСБ 40.0 тэрбум төгрөгийн зээл авсан байна.

Хүснэгт 15 Дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/

Авсан зээлийн хэмжээ	ББСБ тоо	Нийт зээлд эзлэх хувь	Зээлийн хэмжээ
1 тэрбумаас дээш	19	88.7%	98.5
0.1-0.9 тэрбум	37	10.6%	11.7
0.1 тэрбумаас доош	15	0.7%	0.7
НИЙТ	71	100.0%	111.0

Хүснэгт 16 Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/


Авсан зээлийн хэмжээ	ББСБ тоо	Нийт зээлд эзлэх хувь	Зээлийн хэмжээ
1 тэрбумаас дээш	2	97.4%	39.0
0.1-0.9 тэрбум	2	2.5%	1.0
0.1 тэрбумаас доош	1	0.1%	0.1
НИЙТ	5	100.0%	40.0

Банк санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн 64.2 хувийг дотоодын, 33.6 хувийг гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, 2.2 хувийг дотоодын банк санхүүгийн байгууллагаас авсан хугацаа хэтэрсэн 5 ББСБ-ын 13.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

- **Бусад эх үүсвэр**

Бусад эх үүсвэрийн 15.7 тэрбум төгрөгийг 12 ББСБ бүрдүүлж байгаа ба энэ нийт пассивын 1.2 хувьтай тэнцэж байна.

Зураг 18 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/



Энэ нь өмнөх оноос 2.3 дахин буюу 8.9 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ. Энэхүү өсөлтийн 90.8 хувийг факторингийн үйлчилгээний өглөг бүрдүүлж байна.

Бусад эх үүсвэрийн 51.9% буюу 8.1 тэрбум төгрөг нь факторингийн үйлчилгээний өглөг, 25.7% буюу 4.0 тэрбум төгрөг нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг, 22.4% буюу 3.5 тэрбум төгрөг нь төлбөр тооцооны үйлчилгээний өглөг байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар факторингийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 22 ББСБ-аас 2 ББСБ нь 8.1 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 25 ББСБ-аас 9 ББСБ нь 4.0 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах тусгай зөвшөөрөлтэй 3 ББСБ-аас 1 ББСБ нь төлбөр тооцооны үйлчилгээний 3.5 тэрбум төгрөгийн өглөгтэй гарчээ.

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн 62.8 хувийг 2 ББСБ-ийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бол факторингийн үйлчилгээний өглөгийн 79.2 хувийг 1 ББСБ-ийн үлдэгдэл бүрдүүлж байна.

- **ББСБ-аас гаргасан өрийн бичиг**

2018 оны жилийн эцсийн байдлаар 19 ББСБ 23.5 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргасан нь өмнөх оноос 3.4 дахин буюу 16.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны мөн үеэс 3.4 дахин өссөн өсөлтөд шинээр 12 ББСБ 11.0 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргаж эх үүсвэр татсан нь 66.4% нөлөөлжээ. 5 ББСБ нэмж 6.3 тэрбум төгрөгийн өрийн бичгээр хөрөнгө оруулалт татсан бол 1 ББСБ-ын өрийн бичгийн хэмжээ 9 сая төгрөгөөр буурч, 1 ББСБ зах зээлээс өрийн бичгээ бүрэн татсан байна.


- **Төслийн зээл санхүүжилт**

2018 онд 39 ББСБ 17.8 тэрбум төгрөгийн төслийн зээлтэй байгаа нь нийт хөрөнгийн

1.4 хувийг эзэлж байгаа ба өмнөх оноос 20.0% буюу 2.9 тэрбум төгрөгөөр өсчээ.

Төслийн санхүүжилтийн 82.5% буюу 14.7 тэрбум төгрөгийг төгрөгийн, 17.5% буюу 3.1 тэрбум төгрөгийг валютын санхүүжилт бүрдүүлж байна.

Зураг 19 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/




Богино хугацаат санхүүжилтээр 15 ББСБ 3.6 тэрбум төгрөг, урт хугацаат санхүүжилтээр 27 ББСБ 14.2 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан байна.

Төслийн зээлийн 55.6% буюу 9.9 тэрбум төгрөгийг гадаад байгууллагаас, 33.4% буюу 5.9 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагаас, 7.6% буюу 1.4 тэрбум төгрөгийг Засгийн газрын төслийн зээлийн санхүүжилтээс, 3.5% буюу 620.7 сая төгрөгийг бусад төслийн санхүүжилтээс бүрдүүлсэн байна.

• Бусад өр төлбөр

Зураг 20 Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг /сая төгрөгөөр/



2018 оны жилийн эцсийн байдлаар 484 ББСБ 41.8 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь нийт

пассивын 3.3 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оноос 36.9% буюу 11.3 тэрбум төгрөгөөр өссөн дүн юм.

Бусад өр төлбөрийн 77.7% буюу 32.5 тэрбум төгрөгийг бусад пассив, 22.3% буюу 9.3 тэрбум төгрөгийг хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг бүрдүүлж байна.

Бусад пассивын задаргаа:


Хүснэгт 17 Бусад пассив /сая төгрөгөөр/

2018	Дүн	Эзлэх хувь
БУСАД ПАССИВ	32,519.91	100.0%
Бусад өглөг	21,706.1	66.7%
Татварын өглөг	7,063.4	21.7%
Салбар хоорондын тооцооны өглөг	2,571.8	7.9%
Ногдол ашгийн өглөг	734.3	2.3%
Цалингийн өглөг	259.4	0.8%
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	173.5	0.5%
Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн өглөг	11.4	0.03%

3.2 Өөрийн хөрөнгө

2018 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын пассив 32.6% буюу 315.7 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 69.5 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Зураг 21 Өөрийн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/



2018 оны жилийн эцсийн байдлаар өөрийн хөрөнгийн 75.8% буюу 740.8 тэрбум төгрөг нь хувь нийлүүлсэн хөрөнгө, 23.0% буюу 224.6 тэрбум төгрөгийг хуримтлагдсан ашиг, 1.1% буюу 10.6 тэрбум төгрөгийг бусад өмч, 0.1% буюу 966.6 сая төгрөгийг

хоёрдогч өглөг, 0.1% буюу 532.7 тэрбум төгрөгийг сангууд бүрдүүлж байна.

3.3 Хорооны 2017 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт

Хорооны 2017 оны 27 дугаар тогтоолын дагуу үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд байршлаас хамаарч, 4 жил дарааллан хуваарийн дагуу хувь нийлүүлсэн хөрөнгөө /цаашид “ХНХ” гэх/ нэмэгдүүлэх шийдвэр гарсан. 2018 оны 02 сарын 10-ны дотор Улаанбаатар хотод нэг тэрбум төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 250.0 сая төгрөг, бусад аймаг сумдад 70.0 сая төгрөг хүргэх тогтоолын дагуу жилийн эцсийн байдлаар 301 ББСБ 123.6 тэрбум төгрөгөөр ХНХ-өө нэмэгдүүлсэн ба биелэлт 98.0%-тай байна.

ББСБ-уудын ХНХ-өө нэмэгдүүлж буй явц 2018 оны жилийн эцсийн байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт 18 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Улаанбаатар хот/

Огноо	Улаанбаатар хот			Эзлэх хувь	
	Интервал /тэрбум төгрөг/	ХНХ	ББСБ тоо	Дүн	Тоо
2018.02.10	1.0 -1.3	278.0	271	38.8%	58.2%
2019.02.10	1.4-1.8	67.0	44	9.4%	9.4%
2020.02.10	1.9-2.4	62.8	30	8.8%	6.4%
2021.02.10	2.5-аас дээш	295.4	75	41.3%	16.1%
Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг		10.2	43	1.4%	9.2%
1.0 тэрбум хүргэх шаардлага хангаагүй		2.5	3	0.3%	0.6%
НИЙТ		715.9	466	100%	100%

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 466 ББСБ-аас 3 ББСБ ХНХ-ийн доод хэмжээг хангаж ажиллаагүй ба үүнээс 2 ББСБ-ын үйл ажиллагааг 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсэн, 1 ББСБ шаардлага хангаж ажиллаагүй байна.

Хүснэгт 19 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сум/

Огноо	Дархан хот, Эрдэнэт хот			Эзлэх хувь	
	Интервал /сая.төг/	ХНХ /тб.төг/	ББС Б тоо	Дүн	Тоо
2018.02.10	250.0-349.9	1.4	5	13.0%	41.7%
2019.02.10	350.0-474.9	1.2	3	11.1%	25.0%
2020.02.10	475.0-599.9	0.5	1	4.6%	8.3%
2021.02.10	600.0-аас дээш	7.7	3	71.3%	25.0%
НИЙТ		10.8	12	100%	100%

Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад үйл ажиллагаа эрхэлж буй 12 ББСБ ХНХ-ийн доод хэмжээг бүрэн хангаж ажилласан байна.

Хүснэгт 20 Хувь нийлүүлсэн хөрөнгө /Бусад аймаг, сумдад/


Огноо	Бусад аймаг, сумдад			Эзлэх хувь	
	Интервал /сая төгрөг/	ХНХ /тб.төг/	ББСБ тоо	Дүн	Тоо
2018.02.10	70.0-99.9	1.6	22	8.6%	36.1%
2019.02.10	100.0-144.9	0.9	8	4.5%	13.1%
2020.02.10	145.0-199.9	0.4	3	2.4%	4.9%
2021.02.10	200.0-аас дээш	15.4	22	81.6%	36.1%
Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг		0.4	3	2.1	4.9%
70.0 сая хүргэх шаардлага хангаагүй		0.2	3	0.8	4.9%
НИЙТ		18.9	61	100%	100%

Бусад аймаг, сумдад үйл ажиллагаа эрхэлж буй 61 ББСБ-аас 3 ББСБ ХНХ-ийн доод хэмжээг хангаж ажиллаагүй ба үүнээс 2 ББСБ-ын үйл ажиллагааг 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсэн бол 1 ББСБ шаардлага хангаж ажиллаагүй байна.

4. ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 259.5 тэрбум төгрөгийн орлого олж, 158.4 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 101.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.


Зураг 22 Ашигт ажиллагааны үзүүлэлт



4.1 Орлого

2018 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.5% буюу 63.6 тэрбум төгрөгөөр өсч 259.5 тэрбум төгрөгт хүрчээ. Өмнөх оны мөн үеэс хүүгийн орлого 35.4% буюу 40.6 тэрбум төгрөгөөр, хүүгийн бус орлого 14.3% буюу 2.8 тэрбум төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны орлого 44.5% буюу 1.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 23 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/



• Хүүгийн орлого


Хүүгийн орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 34.3 хувиар буюу 55.5 тэрбум төгрөгөөр өсөж 484 ББСБ 217.4 тэрбум төгрөгийн хүүгийн орлогын дүнтэй гарсан ба нийт орлогын 83.8 хувийг бүрдүүлж байна.

Хүүгийн орлогыг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн 208.7 тэрбум төгрөгийн орлого, хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн 8.2 тэрбум төгрөгийн орлого, үнэт цаасны хүүгийн 109.5 сая төгрөгийн орлого, 408.7 сая төгрөгийн бусад хүүгийн орлого бүрдүүлж байна.

• Хүүгийн бус орлого

Хүүгийн бус орлого нь 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт орлогын 12.9% буюу 33.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 22.8% буюу 6.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

Зураг 24 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/



Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого өмнөх оноос 27.3% буюу 3.4 тэрбум өгрөгөөр буурч 8.8 тэрбум төгрөгт хүрсэн бол арилжааны орлого 25.3% буюу 897.4 сая төгрөгөөр өсөж 4.4 тэрбум төгрөг, санхүүгийн үйлчилгээний орлого 74% буюу 8.6 тэрбум төгрөгөөр өсөж 20.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Санхүүгийн үйлчилгээний орлогын 65.5 хувийг үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого, 27.2 хувийг бусад орлого, 6.6 хувийг мөнгөн гуйвуулгын орлого, 0.8 хувийг санхүүгийн зөвөлгөө, мэдээлэл өгөх

үйлчилгээний орлого, 0.01 хувийг итгэлцлийн үйлчилгээний орлого бүрдүүлж байна.

Хүснэгт 21 Санхүүгийн үйлчилгээний орлого /сая төгрөгөөр/

Санхүүгийн үйлчилгээний орлого	2017	2018	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Итгэлцлийн үйлчилгээний орлого	-	2.8	2.82	-
Мөнгөн гуйвуулгын орлого	913.8	1,332.3	418.5	45.8%
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	174.1	155.3	(18.8)	-10.8%
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	6,625.7	13,262.2	6,636.5	2 дахин
Бусад	3,931.7	5,509.5	1,577.8	40.1%
НИЙТ	11,645.4	20,262.2	8,616.8	74.0%

- **Үндсэн бус үйл ажиллагааны орлого**

Үндсэн бус үйл ажиллагааны орлого нийт орлогын 3.3 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 тэрбум төгрөг буюу 28.2 хувиар өсөж 8.6 тэрбум төгрөгт хүрчээ.

Зураг 25 Үндсэн бус үйл ажиллагааны орлого



4.2 Зарлага

Хүснэгт 22 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2017	2018	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Хүүгийн зардал	14.2	20.6	6.4	44.7%
Хүүгийн бус зардал	79.3	96.0	16.7	21.1%
Болзошгүй эрсдэлийн зардал	24.4	24.0	-0.4	-1.8%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	2.2	3.9	1.7	76.7%
Орлогын албан татварын зардал	9.0	14.0	5.0	55.1%
Нийт зарлага	129.1	158.4	29.3	22.7%

2018 онд 158.4 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан нь өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 22.7 хувиар өссөн үзүүлэлт байна.

Үндсэн бус үйл ажиллагааны зардал 76.7% буюу 1.7 тэрбум төгрөгөөр, орлогын албан татварын зардал 55.1% буюу 4.9 тэрбум төгрөгөөр, хүүгийн зардал 44.7% буюу 6.4 тэрбум төгрөгөөр, хүүгийн бус зардал 21.1% буюу 16.7 тэрбум төгрөгөөр өссөн бол болзошгүй эрсдэлийн зардал 1.8% буюу 442.6 сая төгрөгөөр буурчээ.

- **Хүүгийн зардал**

Хүүгийн зардал нийт зардлын 13.0% буюу 20.6 тэрбум төгрөг байна. 2017 оны мөн үеийн дүнтэй харьцуулахад 44.7% буюу 6.4 тэрбумаар өссөн байна.

- **Хүүгийн бус зардал**

Хүүгийн бус зардал нь 96.9 тэрбум төгрөг буюу нийт зардлын 60.7 хувийг бүрдүүлж байна. 2017 оны мөн үетэй харьцуулахад 21.1% буюу 16.7 тэрбум төгрөгөөр өсжээ.

- **Болзошгүй эрсдэлийн зардал**

Нийт зардлын 15.1% буюу 23.9 тэрбум төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал бүрдүүлж байгаа ба энэ зардал нь өмнөх оны мөн үеэс 1.8% буюу 442.6 сая төгрөгөөр буурсан дүнтэй гарсан байна.

- **Үндсэн бус үйл ажиллагааны зардал**

Нийт зардлын 2.4% буюу 3.9 тэрбум төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны зардал бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс 76.7% буюу 1.7 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарчээ.

- **Орлогын албан татварын зардал**

Нийт зардлын 8.8% буюу 13.9 тэрбум төгрөгийг орлогын албан татварын зардал бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс 55.1% буюу 4.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарчээ.


4.3 Ашигт ажиллагаа

2018 онд ББСБ-ууд 101.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 34.3 тэрбум төгрөгөөр буюу 51.4 хувиар өссөн үзүүлэлт юм.

2018 онд 539 ББСБ-ын 461 нь буюу 85.5% нь 109.0 тэрбум төгрөгийн ашигтай, 65 нь буюу 12.1% нь 7.9 тэрбум төгрөгийн алдагдалтай, 13 нь буюу 2.4% нь үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ашиг 51.4 хувийн өсөлттэй гарчээ.

Зураг 26 Ашигийн өсөлт /хувиар/



5. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 539 ББСБ-ын 88.5% буюу 477 ББСБ үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна. Нийт ББСБ-уудын 11.5% нь буюу 62 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 46 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 14 ББСБ, 5 ба түүнээс дээш зохистой харьцаа алдагдсан 2 ББСБ байна.

Зураг 27 Зохистой харьцаа



5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих

зохистой харьцааны 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 23 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	42	89.4%
1 зохистой харьцааг хангаагүй	1	2.1%
2 зохистой харьцааг хангаагүй	4	8.5%
3 зохистой харьцааг хангаагүй	-	-
4 зохистой харьцааг хангаагүй	-	-
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	-	-
НИЙТ	49	100%

5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 14 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 24 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	410	88.7%
1 зохистой харьцааг хангаагүй	41	8.9%
2 зохистой харьцааг хангаагүй	9	1.9%
3 зохистой харьцааг хангаагүй	0	0%
4 зохистой харьцааг хангаагүй	0	0%
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	2	0.4%
НИЙТ	462	100%

5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.4-т заасан хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих 18 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 25 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШҮ

Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
Зохистой харьцааг бүрэн хангасан	25	83.3%
1 зохистой харьцааг хангаагүй	4	13.3%
2 зохистой харьцааг хангаагүй	1	3.3%
3 зохистой харьцааг хангаагүй	0	0%
4 зохистой харьцааг хангаагүй	0	0%
5 ба дээш зохистой харьцааг хангаагүй	0	0%
НИЙТ	50	100%

Хүснэгт 26 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Журмын ...-г заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд			ЗХШҮ хангаагүй		ЗХШҮ хангасан		ЗХШҮ хангах шаардлагатай ББСБ-ын тоо
		3.4	3.3	3.2	ББСБ тоо	%	ББСБ тоо	%	
Хангах шаардлагатай ЗХШҮ-ийн тоо									
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	0	5	3	8	1.5%	531	98.5%	539
2	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	0	8	4	12	2.2%	527	97.8%	539
3	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	0	3	1	4	0.7%	535	99.3%	539
4	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	0	14	0	14	2.6%	525	97.4%	539
5	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	2	17	1	20	3.7%	519	96.3%	539
6	Өрийн бичгийн зохистой харьцаа	0	0	0	0	0%	539	100%	539
7	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу)	0	0		0	0%	492	100%	492
8	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	0	0		0	0%	492	100%	492
9	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	2	11		13	2.6%	479	97.4%	492
10	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	0	6		6	1.2%	486	98.8%	492
11	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	1	3		4	0.8%	488	99.2%	492
12	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	0	2		2	0.4%	490	99.6%	492
13	Үнэт цаасны эзэмшил, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	0	0		0	0%	492	100%	492
14	Нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	0	0		0	0%	492	100%	492
15	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	0			0	0%	30	100%	30
16	Компанийн өрийн бичиг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	0			0	0%	30	100%	30
17	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	0			0	0%	30	100%	30
18	Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	1			1	3.30%	29	96.7%	30
ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо		24	393	38					
ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо		6	69	9	539				
НИЙТ ББСБ-ИЙН ТОО		30	462	47					

* Байвал зохих зохистой харьцаа
% Нийт ББСБ-ын тоонд эзлэх хувь

2018 оны жилийн эцсийн байдлаар үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 20 ББСБ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 14 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 13 ББСБ, өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 12 ББСБ мөн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцааг 8 ББСБ тус тус хангаагүй буюу эдгээр таван зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хамгийн их алдагдсан байна.

6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд

- Ерөнхий статистик

Тайлант онд хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 73 ББСБ, 173 хувьцаа эзэмшигч, 182 ажилтан, 4 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 25,356 харилцагч, 7,608 зээлдэгчдэд хүрч ажиллаж байна.

Хамгийн олон ББСБ-тай аймгууд нь Төв аймаг 11, Дорнод аймаг болон Орхон аймагт тус тус 7 ББСБ байршиж байна.

Зураг 28 Орон нутгийн ББСБ-ууд, орон нутаг дахь салбаруудын тархалт



Хүснэгт 27 Орон нутгийн ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл /давхардсан тоогоор/

№	Үйл ажиллагааны төрөл	ТЗ-ын тоо
1	Зээл	70
2	Гадаад валютын арилжаа	6
3	ХОСЧЗМӨ	1
4	Итгэлцлийн үйлчилгээ	1
НИЙТ		82

ББСБ-ын 4 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 78 үйл ажиллагаа орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. 33 ББСБ буюу 45.2% нь санхүүгийн програмтай байна.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт зээлдэгчдийн 91.5% буюу 6,958 нь хэвийн, 2.9% буюу 223 нь хугацаа хэтэрсэн, 5.6% буюу 427 нь чанаргүй зээлдэгчид байна.

ББСБ-уудын зээлдэгчдийн насжилтаар авч үзвэл орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт

зээлдэгчдийн 71.9% буюу 5440 нь 18-45 насны, 20.1% буюу 1,523 нь 46-55 насны, 8% буюу 608 нь 55-аас дээш насны иргэд байна. Боловсролын түвшний хувьд дээд болон тусгай дунд боловсролтой иргэд 67.0%, бүрэн дунд боловсролтой иргэд 25.1%, бага болон дунд боловсролтой иргэд 7.8 хувийг бүрдүүлж байна.

- **Актив**

Салбарын нийт активын 2.3 хувийг бүрдүүлж байгаа хөдөө орон нутгийн ББСБ-уудын 30.2 тэрбум төгрөгийн актив хөрөнгийн 6.3 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө, 163.2 сая төгрөг нь богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/, 20.6 тэрбум нь зээл /цэврээр/, 242.9 тэрбум төгрөг нь өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр), 1.9 тэрбум төгрөгийг бусад хөрөнгө


бүрдүүлж байгаа ба үндсэн ба биет бус хөрөнгө цэврээр 945.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 28 Орон нутгийн ББСБ-уудын активын бүтэц

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
<i>Эргэлтийн хөрөнгө</i>	29,240.3	96.9%
Мөнгөн хөрөнгө	6,259.4	20.7%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	163.2	0.5%
Нийт зээл	25,437.6	84.3%
(Зээлийн эрсдэлийн сан)	4,846.0	16.1%
Зээл (цэврээр)	20,591.6	68.2%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	-	0.0%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	243.0	0.8%
Бусад хөрөнгө	1,983.2	6.6%
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>	945.6	3.1%
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	1,324.0	4.4%
(Хуримтлагдсан элэгдэл)	378.5	1.3%
Нийт хөрөнгийн дүн	30,185.8	100.0%

Зээлийн хувьд 19.6 тэрбум төгрөгийн хэвийн зээл, 748.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 5.1 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Зээлийн эрсдэлийн санг хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 82.9%-д байгуулжээ.

Зураг 29 Орон нутгийн ББСБ-уудын зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/



1.3 тэрбум төгрөгийн үндсэн (биет) ба биет бус хөрөнгөнд 378.4 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна.

- **Пассив**

Хөдөө орон нутгийн 73 ББСБ-ын хөрөнгийн 92.2% буюу 27.8 тэрбум төгрөг нь эздийн өмч, 7.8% буюу 2.4 тэрбум төгрөг нь өр төлбөр байна. Хөдөө орон

нутгийн ББСБ-уудын нийт хөрөнгийн 81.6 хувийг буюу 24.6 тэрбум төгрөгийг хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдүүлж байгаа ба энэ нь салбарын хувьцаат капиталын 3.3 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 29 Орон нутгийн ББСБ пассивын бүтэц

Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум.төг/	Дүн	Хувь
<i>Өр төлбөр</i>	2.36	7.8%
Санхүүгийн эх үүсвэр	1.13	3.7%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	0.16	0.5%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	0.10	0.3%
Төслийн зээлийн санхүүжилт	0.68	2.3%
Бусад өр төлбөр	0.29	1.0%
<i>Эздийн өмч</i>	27.83	92.2%
Хувьцаат капитал	24.64	81.6%
Бусад өмч	0.35	1.1%
Сангууд	0.44	1.5%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	2.40	7.9%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	30.19	100.0%

- **Орлого үр дүнгийн тайлан**

2018 онд хөдөө орон нутгийн ББСБ-ууд 6.8 тэрбум төгрөгийн орлоготой, 3.5 тэрбум төгрөгийн зарлагатай, 3.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаа. Орлогын 90.1 хувийг хугацаандаа байгаа хүүгийн орлого бүрдүүлж байна. Нийт зардлын 74.2% буюу 2.6 тэрбум төгрөгийг хүүгийн бус зардал, 9.2% буюу 318.4 сая төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал эзэлж байна.

6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд

- **Ерөнхий статистик**

Хүснэгт 30 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл /давхардсан тоогоор/

Үйл ажиллагааны төрөл	ТЗ-ын тоо
Зээл	29
Факторингийн үйлчилгээ	2
Төлбөрийн баталгаа гаргах	5
Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	1
Гадаад валютын арилжаа	11
Итгэлцлийн үйлчилгээ	3
Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2
Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	4
НИЙТ	57

Тайлант улиралд гадаадын хөрөнгө оруулалттай 100 хувийн болон хамтарсан

хөрөнгө оруулалттай, 9 улсын, 68 хувьцаа эзэмшигчийн 29 ББСБ, 29 салбар, 3 төлөөлөгчийн газар, 8 төрлийн 57 тусгай зөвшөөрлийн хүрээнд 302 ажилтантайгаар 30543 харилцагч, 18733 зээлдэгчдэд хүрч үйл ажиллагаа явуулж байна. 24 ББСБ буюу 82.8% нь үйл ажиллагаандаа санхүүгийн програм ашиглаж байна.

Үүнээс гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай 7 улсын, 20 хувьцаа эзэмшигчийн 16 ББСБ, хамтарсан хөрөнгө оруулалттай 7 улсын, 48 хувьцаа эзэмшигчийн 13 ББСБ байна.

- **Актив**

Гадаадын хөрөнгө оруулалттай 29 ББСБ-ын хөрөнгө 183.8 тэрбум төгрөг нь нийт хөрөнгийн 14.3 хувийг бүрдүүлж байна.

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
<i>Эргэлтийн хөрөнгө</i>	179,435.8	97.6%
Мөнгөн хөрөнгө	22,720.0	12.4%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	0.1	0.0%
Нийт зээл	148,574.1	80.8%
(Зээлийн эрсдэлийн сан)	11,305.4	6.2%
Зээл (цэврээр)	137,268.7	74.7%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	232.7	0.1%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	2,389.8	1.3%
Бусад хөрөнгө	16,824.5	9.2%
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>	4,334.6	2.4%
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	5,955.6	3.2%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,621.0	0.9%
Нийт хөрөнгийн дүн	183,770.4	100.0%

- **Пассив**

Пассивын 48.0% буюу 67.8 тэрбум төгрөгийг өр төлбөр, 52.0% буюу 73.4 тэрбум төгрөгийг эздийн өмч эзэлж байна.

Нийт 539 ББСБ-ын пассивын бүтэц нь эздийн өмч давамгайлсан бүтэцтэй байдаг бол гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын хувьд өр төлбөр болон эздийн өмчийн харьцаа ойролцоо дүнтэй байна. Өр төлбөрийн 62.6% нь дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээл байгаа бол эздийн өмчийн 76.6% нь хувьцаат капитал байна.

Хүснэгт 31 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив

Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	Дүн	Хувь
<i>Өр төлбөр</i>	90.71	49.8%
Санхүүгийн эх үүсвэр	18.42	10.1%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	56.74	31.1%
Бусад эх үүсвэр	-	0.0%
Төслийн зээлийн санхүүжилт	8.62	4.7%
Бусад өр төлбөр	6.93	3.8%
<i>Эздийн өмч</i>	91.48	50.2%
Хувьцаат капитал	69.47	38.1%
Бусад өмч	0.91	0.5%
Сангууд	0.00	0.0%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	21.09	11.6%
НИЙТ ПАССИВ	182.2	100.0%

Дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн 44.6% буюу 25.3 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагуудаас, 55.4% буюу 31.4 тэрбум төгрөгийг гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас авсан өр төлбөр эзэлж байна.

- **Орлого үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаанд гадаадын хөрөнгө оруулалттай 29 ББСБ 44.2 тэрбум төгрөгийн орлоготой, 34.1 тэрбум төгрөгийн зарлагатай, 10.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

6.3 Гадаад валютын арилжааны ББСБ-ууд

- **Ерөнхий статистик**

Нийт 539 ББСБ-уудын 8.2%, гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй нийт 157 ББСБ-уудын 28.0% буюу 44 ББСБ гадаад валютын арилжаа дагнан эрхэлж байгаа ба эдгээр нь 63 хувьцаа эзэмшигч, 6 салбар, 133 ажилтантайгаар 69029 харилцагчдад хүрч үйлчилж байна.

Гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 157 ББСБ байгаагаас дагнан эрхэлж байгаа 44 ББСБ-уудын 41 нь Улаанбаатар хотод, 3 ББСБ орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

- **Актив**

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын нийт активын хэмжээ 10.8

тэрбум төгрөг байгаа нь салбарын активын 0.8% байна. Үйл ажиллагааны онцлогоос хамааран нийт активын 96.9% нь мөнгөн хөрөнгө, 0.01% нь богино хугацаат хөрөнгө оруулалт, 0.3% нь өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө, 0.9% нь бусад хөрөнгө байгаа бөгөөд “Уран Уургач ББСБ” ХХК 1 сая төгрөгийн засгийн газрын арилжааны үнэт цаас худалдаж авсан байна. 325.5 сая төгрөгийн үндсэн /биет/ ба биет бус хөрөнгөнд 124.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцжээ.

Хүснэгт 32 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив /мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
<i>Эргэлтийн хөрөнгө</i>	10,653.0	98.1%
Мөнгөн хөрөнгө	10,515.6	96.9%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	1.0	0.01%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	36.6	0.3%
Бусад хөрөнгө	99.8	0.9%
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>	201.3	1.9%
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	325.5	3.0%
(Хуримтлагдсан элэгдэл)	124.2	1.1%
НИЙТ ХӨРӨНГӨ	10,854.3	100.0%

- **Пассив**

Хүснэгт 33 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив /сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Дүн	Хувь
Бусад өр төлбөр	118.0	1.1%
Хувьцаат капитал	10,004.9	92.2%
Бусад өмч	27.8	0.3%
Хуримтлагдсан ашиг	703.6	6.5%
Нийт пассив	10,854.3	100.0%

Нийт хөрөнгийн 92.3% буюу 11.1 тэрбум төгрөг нь хувьцаат капитал, 5.1% буюу 613.6 сая төгрөг нь хуримтлагдсан ашиг, 2.3% буюу 280.5 сая төгрөг нь өр төлбөр, 0.2% буюу 29.7 сая төгрөг нь бусад өмч байна.

- **Орлого үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаанд 1,356.2 сая төгрөгийн орлоготой, 1,147.5 сая төгрөгийн зарлагатай, 208.7 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

28 ББСБ 286.4 сая төгрөгийн ашигтай, 13 ББСБ 77.7 сая төгрөгийн алдагдалтай, 3 ББСБ үйл ажиллагаа явуулаагүй байна.


Хүснэгт 34 Орлогын бүтэц /мянган төгрөгөөр/

НИЙТ ОРЛОГО	1,356,176.84	100.0%
Хүүгийн орлого	16,634.83	1.2%
Хүүгийн бус орлого	1,334,169.25	98.4%
<i>Гадаад валютын арилжааны орлого</i>	1,260,081.08	92.9%
<i>Хани болон үнэлгээний тэгшитгэлийн орлого</i>	70,001.87	5.2%
<i>Санхүүгийн үйлчилгээний орлого</i>	4,086.30	0.3%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	5,372.76	0.4%

Зарлагын бүтцийн 96.1% нь хүүгийн бус зардал, 1.0% нь үндсэн бус үйл ажиллагааны зардал, 2.9% нь орлогын албан татварын зардал байна.

Хүүгийн бус зардлын бүтцийг авч үзвэл:


Зураг 30 Хүүгийн бус зардлын бүтэц



- **Гадаад валютын арилжааны дүн мэдээ**

Хорооны гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 157 ББСБ-уудын 2018 оны жилийн эцсийн арилжааны дүн мэдээгээр 1061.3 сая төгрөгийн гадаад валют худалдан авч 1061.6 сая төгрөгийн гадаад валют зарсан байна.

Зураг 31 ГВА эрхэлдэг ББСБ-уудын арилжааны дүн /2016-2018 он/



2018 оны 12 сард 101 ББСБ валют арилжааны дүн мэдээ ирүүлсэн байна.

Хүснэгт 35 ГВА эрхэлдэг ББСБ-уудын арилжааны дүн мэдээ /2018 он/

ББСБ-ын валют арилжааны дүн	Худалдаж авсан	Зарсан
	1,061,262,122,108.99	1,061,560,220,589.08
БНХАУ-ын юань	449,487,589,796.36	454,838,515,830.70
АНУ-ын доллар	425,979,734,651.20	424,500,394,048.79
Евро	90,578,114,275.70	88,299,092,498.61
БНСУ-ын вон	33,305,647,353.61	33,481,274,250.30
Японы иен	27,794,018,264.50	26,999,303,782.84
ОХУ-ын рубль	20,303,697,482.82	20,709,783,380.97
Английн фунт	4,589,303,012.29	4,421,261,204.97
Швейцарь франк	3,240,779,614.68	2,634,654,502.45
Хонконг доллар	2,314,761,592.32	2,175,080,897.50
Австралийн доллар	1,701,573,480.93	1,605,739,566.56
Сингапурын доллар	1,157,680,480.64	1,055,467,007.33
Канадын доллар	466,319,155.40	453,953,322.72
Шведийн крон	281,240,407.56	286,094,015.35
БНАСАУ-ын вон	49,952,400.00	87,425,530.00
Тайланд бат	7,020,000.00	7,200,000.00
Индонезийн рупп	4,191,515.00	4,408,250.00
Энэтхэгийн рупи	495,000.00	500,000.00
Тайван доллар	0.00	72,500.00
Малайзын ринггит	3,626.00	0.00

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

- Зохицуулалтын үйлчилгээний хөлс: 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 450 ББСБ 868.34 сая төгрөгийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.
- Зээлийн мэдээллийн сан: Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүргийг тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 492 ББСБ-ын 91.5% буюу 450 ББСБ хэрэгжүүлж ажилласан байна.
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх: 2018 онд Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 539 ББСБ-ын 82.6 хувь буюу 445 ББСБ хэрэгжүүлснээс 384 ББСБ аудитаар баталгаажуулсан тайлангаа нийтэд мэдээлсэн байна.
- 20 сая төгрөгөөс дээш гүйлгээг мэдээлэх: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд нэр бүхий 198 ББСБ, 9,948 удаагийн тохиолдлоор, 853.6 тэрбум төгрөгийг /нэр бүхий 5 ББСБ 11 удаагийн 581.3 сая төгрөгийн сэжигтэй гүйлгээ, 197 ББСБ 9,937 удаагийн тохиолдлоор 853.0 тэрбум төгрөгийн 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээлэл/ Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

2018 онд тайлан мэдээг ирүүлбэл зохих 539 ББСБ-аас 97.4% буюу 525 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 14 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

2018 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 4875 хувь нийлүүлэгчдийн 539 ББСБ, 230 салбар нэгж, 5 төлөөлөгчийн газар, 2784 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 1,601,749 харилцагчдад хүрч үйлчилж байна. ББСБ-уудыг төвлөрлөөр авч үзвэл 466 ББСБ, 161 салбар Улаанбаатар хотод, 73 ББСБ, 69 салбар хөдөө орон нутагт бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2018 онд ББСБ-уудын актив 1.3 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 32.6% буюу 315.7 тэрбум төгрөгөөр өсөж банкны салбарын нийт активын 3.9 хувьтай тэнцэж байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 375 ББСБ нийт активын 51.0 хувийг, 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 41 ББСБ нийт активын 45.4 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 123 ББСБ нийт активын 3.1 хувийг бүрдүүлж байна.

Салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 869.2 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын зээлийн өрийн үлдэгдлийн 5.1 хувьтай тэнцэж байгаа бөгөөд үүний 752.9 тэрбум төгрөг буюу 86.6 хувийг хэвийн зээл, 33.4 тэрбум төгрөг буюу 3.8 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 82.9 тэрбум төгрөг буюу 9.5 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 55.4%-д эрсдэлийн сан байгуулсан байна. Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан өмнөх оны мөн үеэс 0.8, 3.2 пунктээр буурсан бол хэвийн зээл 42.9% буюу 225.9 тэрбум төгрөгөөр өсөж нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.0 пунктээр өссөн байна.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 492 ББСБ-аас 450 ББСБ нийт 869.2 тэрбум төгрөгийн зээлийг 3.3 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгосон нь банкны салбартай харьцуулахад 1.9 пунктээр өндөр байна.

ББСБ-уудын пассивын бүтцийг харвал 33.9% буюу 307.5 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 76.1% буюу 977.4 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 77 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 40.8 хувийг эзэлж байна. Нийт ББСБ-уудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.0-2.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 350 ББСБ 56.0 хувийг эзэлж байгаа бол 0.9 тэрбумаас доош хөрөнгөтэй 112 ББСБ 3.2 хувийг бүрдүүлж байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар 539 ББСБ 259.5 тэрбум төгрөгийн орлоготой, 158.4 тэрбум төгрөгийн зарлагатай 101.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. ББСБ-уудын 461 нь буюу 85.5% нь 109.0 тэрбум төгрөгийн ашигтай, 65 нь буюу 12.1% нь 7.9 тэрбум төгрөгийн алдагдалтай, 12 нь буюу 2.4% нь үйл ажиллагаа эрхлээгүй байна. Активын өгөөж 9.0%, өөрийн хөрөнгийн өгөөж 11.7%-тай байна.

Нийт ББСБ-ын 88.5% буюу 477 ББСБ зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан бол үлдэх 62 ББСБ буюу 11.5% нь зохистой харьцааны зарим үзүүлэлтийг хангаагүй байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР